

САНАЛ ХУРААЛТЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ
Бүгд Найрамдах Чех Улс (БНЧУ)-ын Парламентын Сенатын сонгууль, хотын зөвлөлийн сонгууль.

2022 оны 9-р сарын 23-ны Баасан гарагт 14:00-22:00 цагийн хооронд
2022 оны 9-р сарын 24-ний Бямба гарагт 8:00-14:00 цагийн хооронд

Зөвхөн сонгуулийн өдрүүдэд БНЧУ-ын сонгуулийн санал авах байранд санал хураалт явагдана.

Хотын зөвлөлийн сонгуультай цуг сонгуулийн 27 тойрогт Сенатын сонгууль болно. Сонгуулийн санал авах байр, сонгуулийн тойргийн хороод нь эдгээр сонгуульд нийтлэг байдаг. Зөвхөн байнгын оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн тойрогтоо л сонгогч Сенатын сонгуульд саналаа өгч болно. Хэрэв эхний шатны санал хураалтад нэр дэвшигч олонхийн саналаар сонгогдоогүй бол, хоёр дахь шатны санал хураалт явагдана.

Хотын зөвлөлийн сонгуульд, сонгогч нь

- ✓ 2022 оны 9-р сарын 24-ний өдрийн байдлаар доод тал нь 18 нас хүрсэн БНЧУ-ын иргэн, тус хотын байнгын оршин суугч байна,
- ✓ 2022 оны 9-р сарын 24-ний өдрийн байдлаар доод тал нь 18 нас хүрсэн, тус хотод байнгын эсвэл түр оршин суугчаар бүртгүүлсэн, байнгын сонгуулийн нэрсийн жагсаалтад бүртгүүлэх хүсэлт гаргасан ЕХ-ны өөр гишүүн улсын иргэн байна.

Сенатын сонгуульд, сонгогч нь

- ✓ 2022 оны 9-р сарын 24-ний өдрийн байдлаар 18 нас хүрсэн БНЧУ-ын иргэн байна. Харин хоёр дахь шатанд, 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 18 нас хүрсэн БНЧУ-ын иргэн байна.

Биеийн байцаалт

Сонгогч санал авах байранд өөрийн биеийн байцаалт, иргэний харьяаллаа баталгаажуулах ёстой

- ✓ хүчинтэй иргэний үнэмлэх,
- ✓ БНЧУ-ын хүчинтэй аяллын, дипломат эсвэл албаны паспорт, аяллын үнэмлэх,
- ✓ гадаадын иргэдийн хувьд, БНЧУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суух үнэмлэх эсвэл түр оршин суух үнэмлэх.

Шаардлагатай бичиг баримтаар биеийн байцаалт, иргэний харьяаллаа баталгаажуулж чадаагүй сонгогч санал өгөхгүй.

Саналын хуудас

Хотын сонгуулийн саналын хуудсыг хоёр талд нь хэвлэж болно. Энэ тохиолдолд, саналын хуудасны доод талд “Урэлжлэл нь нөгөө талд бий” гэсэн бичиг харагдана.

Нэр дэвшигчийн улс төрийн нам эсвэл улс төрийн хөдөлгөөний гишүүнчлэлийг саналын хуудсан дээр товчилсон үсгээр бичнэ. Хэрэв аль нэг нэр дэвшигчийг бүртгэх үед хасахаар шийдвэрлэсэн бол, тухайн улс төрийн намын саналын хуудсанд тус нэр дэвшигчийн серийн дугаарыг хоосон үлдээнэ.

Сенатын сонгуулийн саналын хуудсыг нэр дэвшигч тус бүрээр тус тусад нь хэвлэдэг.

Саналын хуудас тус бүрд сугалаагаар тодорхойлсон нэр дэвшигчийн дугаар бичигдэнэ. Хэрэв нэр дэвшигчийн хүсэлтийг шүүхээр хянан үзсэний дараа ч гэсэн бүртгүүлээгүй байвал, олгосон саналын хуудсууд нь бүрэн тоон дараалал болохгүй.

Саналын хуудасны загвар, саналын хуудасны хэвлэлтийн алдааны талаарх мэдээллийг санал авах байранд байрлуулна.

Нэр дэвшүүлэхээс татгалзах, нэр дэвшигчийг хасах тухай мэдээлэл

Нэр дэвшигчээс татгалзах, хасах тухай мэдээллийг тухайн санал авах байранд нийтэлнэ. Сонгуулийн дүнг гаргахад ийм нэр дэвшигчийг дэмжсэн саналыг тооцохгүй.

Санал өгөх

Сонгогч бүр өөрийн биеэр санал өгөх ба итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санал өгөхийг хориглоно. Сонгогч нь сонгосон буюу бөглөсөн саналын хуудас бүхий албан ёсны дугтуйг тойргийн сонгуулийн хорооны өмнө байрлах саналын хайрцагт хийж саналаа өгнө. Хөгжлийн бэрхшээлийн улмаас саналын хуудсыг өөрөө сонгох, бөглөх боломжгүй, эсвэл уншиж, бичиж чаддаггүй сонгогчийг тухайн тойргийн сонгуулийн хорооны гишүүн бус өөр нэг сонгогч дагалдаж, саналын хуудсыг бөглөх зориулалттай хэсэгт оруулж болно. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийг дагалдаж буй хүн нь тухайн сонгогчийн өмнөөс саналын хуудсыг сонгох буюу бөглөж, албан ёсны дугтуйнд хийж, шаардлагатай бол албан ёсны дугтуйг саналын хайрцагт хийж болно.

Зөөврийн хайрцгаар санал өгөх

Ноцтой шалтгаанаар, ялангуяа эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байрнаас гадуур зөөврийн хайрцгаар санал өгөх хүсэлтийг сонгогч хотын захиргаанд, харин сонгуулийн өдрүүдэд бол тойргийн сонгуулийн хороонд гаргаж болно. Гэлээ ч, тойргийн сонгуулийн хороо зөвхөн тойргийнхоо нутаг дэвсгэрт зөөврийн хайрцгийн хамтаар тойргийн гишүүдээ илгээнэ.

Хотын зөвлөлийн сонгуульд санал өгөх хэлбэр

Тойргийн сонгуулийн хорооноос албан ёсны тамгатай хоосон дугтуйг сонгогч хүлээн авна. Хүсэлт гаргавал, хороо мөн саналын хуудас өгнө. Саналын хуудсыг бөглөхөд зориулагдсан хэсэгт сонгогч албан ёсны дугтуй, саналын хуудсыг авна.

Тухайн хотод сонгогдох хотын зөвлөлийн гишүүдийн тоог саналын хуудасны орой хэсэгт харуулна.

Саналын хуудсыг дараах хэлбэрүүдийн аль нэгээр бөглөнө. Үүнд:

1. Намын нэрийн өмнөх баганын эхэнд байгаа нүдэнд зөвхөн **нэг улс төрийн намыг** чагталж тэмдэглэнэ. Тухайн хотод сонгогдох хотын зөвлөлийн гишүүдийн тооноос хамаарч энэ нь саналын хуудсанд заасан дарааллаар тус улс төрийн намын нэр дэвшигчдэд санал өгнө.
2. Аливаа улс төрийн намаас нэр дэвшигчдийн нэрийн өмнөх нүдэнд сонгогчийн санал өгөх нэр дэвшигчдийг чагталж тэмдэглэнэ. **Чагталж тэмдэглэх боломжтой нэр дэвшигчдийн дээд тоо нь сонгогдох хотын зөвлөлийн гишүүдийн тоотой таарч байх ёстой.**
3. **Уг хоёр аргыг хослуулж, нэг улс төрийн намыг чагталж тэмдэглээд дараа нь нэр дэвшигчийн нэрийн өмнөх нүдэнд бусад улс төрийн намаас нэр дэвшиж буй бусад нэр дэвшигчдийг тэмдэглэнэ.** Энэ тохиолдолд, тус тусад нь тэмдэглэсэн нэр дэвшигчдэд санал өгнө. Саналын хуудсанд заасан дарааллын дагуу хотын зөвлөлийн

сонгогдсон гишүүдийн үлдсэн тоотой тэнцүү тооны саналыг зөвхөн тэмдэглэгдсэн улс төрийн намаас нэр дэвшиж буй олон нэр дэвшигчид өгнө.

Хэрэв сонгогч улс төрийн намыг нийтэд нь чагталж тэмдэглэсэн бол, тухайн намаас тодорхой нэр дэвшигчдийг чагталж тэмдэглэх боломжгүй болно. Энэ тохиолдолд, тухайн улс төрийн намаас нэр дэвшигчдийн тэмдэглэгээг тооцохгүй.

Сонгогч хотын сонгуульд зориулсан саарал өнгийн дугтуйнд бөглөсөн саналын хуудсыг хийнэ.

Хэрэв сонгогч саналын хуудсан дээр аливаа улс төрийн нам, нэр дэвшигчийг тэмдэглэгээгүй, саналын хуудсыг албан ёсны дугтуйнд хийгээгүй, саналын хуудсыг урсан эсвэл нэг хотын зөвлөлийн хэд хэдэн саналын хуудсыг албан ёсны дугтуйнд хийсэн бол, санал хүчингүй болно.

Хотын дүүргүүд дэх хотын зөвлөлд санал өгөх

Бие даасан засаглалтай хотуудын нутаг дэвсгэрийн нэгж болон нийслэл Прага хотод санал өгөх тохиолдолд, сонгогч хоёр саналын хуудсыг нэг албан ёсны дугтуйнд хийнэ. Хоёр саналын хуудас нь бие даасан засаглалтай хотын нутаг дэвсгэрийн нэгж эсвэл нийслэл Прага хотын хотын зөвлөлийн сонгуулийн саналын хуудас (тус саналын хуудасны зүүн талд босоо ягаан судлаар тэмдэглэсэн), тухайн тойргийн хотын зөвлөлийн сонгуулийн саналын хуудас байна.

БНЧУ-ын гадаад дахь Элчин сайдын яаманд бүртгэлтэй сонгогчид хотын зөвлөлийн сонгуульд санал өгөх

Хотын сонгуульд гадаадаас санал өгөх боломжгүй. Гадаадад байгаа сонгогчдын тусгай жагсаалтад бүртгэгдсэн сонгогч тухайн хотын захиргаанд, эсвэл сонгууль болох өдөр тойргийн сонгуулийн хороонд Элчин сайдын яам эсвэл консулын газраас тухайн сонгогч нь сонгогчдын тусгай жагсаалтаас хасагдсан тухай тодорхойлолт ирүүлсэн бол, хотын сонгуульд саналаа өгч болно.

Сенатын сонгуульд хэрхэн санал өгөх тухай

Тойргийн сонгуулийн хорооноос албан ёсны тамгатай хоосон дугтуйг сонгогч хүлээн авна. Хүсэлт гаргавал, Хороо мөн багц саналын хуудас өгнө. Албан ёсны дугтуй, саналын хуудас авсан сонгогч саналын хуудсыг бөглөхөд зориулагдсан хэсэгт орно. **Санал өгөхөөр шийдсэн нэр дэвшигчээ сонгосон нэг саналын хуудсыг сонгогч албан ёсны дугтуйнд хийнэ. Саналын хуудсыг ямар нэг хэлбэрээр өөрчилж болохгүй.**

Сенатын сонгууль нь хотын сонгуультай цуг явагддаг. Сонгууль тус бүрийн албан ёсны дугтуй, саналын хуудас нь өнгөөрөө ялгарна. Хотын зөвлөлийн сонгуулийн саналын хуудас, албан ёсны дугтуй саарал өнгөтэй, Сенатын сонгуулийн саналын хуудас, албан ёсны дугтуй шар өнгөтэй байна. Сонгууль зэрэг явуулах тохиолдолд, саарал саналын хуудсыг албан ёсны саарал дугтуйнд хийж, шар саналын хуудсыг албан ёсны шар дугтуйнд хийх нь чухал. Эс бөгөөс, санал хүчингүй болно. Сонгогч албан ёсны дугтуйнд саналын хуудсыг хийхдээ, нэгээс олон саналын хуудсыг андуурч (наалдсан гэх мэт шалтгааны улмаас) хийхээс болгоомжлох ёстой. Ийм тохиолдолд, санал хүчингүй болно.

Тогтсон маягт дээр хэвлэгдээгүй саналын хуудас, урагдсан саналын хуудас, дугтуйнд хийгдээгүй саналын хуудсууд мөн хүчингүй болно.

Сенатын сонгуульд сонгогчийн үнэмлэхээр санал өгөх

Хэрэв сонгогч Сенатын сонгуульд сонгогчийн үнэмлэх ашигласан бол, үнэмлэхээ тойргийн сонгуулийн хороонд буцааж өгөх шаардлагатай. Хорооны зүгээс албан ёсны тамгатай хоосон дугтуй, саналын хуудсыг багцаар нь сонгогчид олгоно. Сонгууль болж буй нутаг дэвсгэрт

байнгын оршин суугчаар бүртгэгдсэн аль ч тойрогт сонгогч нь сонгогчийн үнэмлэхээрээ санал өгч болно. Энэ нь БНЧУ-ын элчин сайдын яам эсвэл консулын газарт бүртгүүлсэнд үндэслэж сонгогчийн үнэмлэх авсан сонгогчид хамаарахгүй. Ийм сонгогч тухайн жилд сонгууль зарласан аль ч тойрогт саналаа өгч болно.

Сонгогчийн оршин суугаа сонгуулийн тойргоос гадуурх Сенатын сонгуульд санал өгөх

Сенатын сонгуульд санал өгөх эрх нь сонгогч тухайн сонгуулийн тойрогт байнга оршин суудаг байх нөхцөлтэй байдаг. БНЧУ-ын нутаг дэвсгэрт байнгын сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч зөвхөн өөрийн сонгуулийн тойрогт сонгууль болсон жилд л Сенатын сонгуульд санал өгч болно. **Хэрэв сонгогч сонгуулийн тойргоосоо гадуур байгаа эсвэл сонгуулийн өдөр гадаадад байгаа (эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, томилолтоор явах гэх мэт шалтгааны улмаас) бол, энэ нь сонгох эрхээ хэрэгжүүлэхэд бодит саад учруулна.** Гадаад дахь БНЧУ-ын элчин сайдын яам эсвэл консулын газарт сонгогчдын тусгай жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдод дээрх заалт хамаарахгүй.

Сенатын сонгуулийн хоёр дахь шат

Хэрэв эхний шатны сонгуулийн санал хураалтад нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн саналыг авч чадаагүй бол, ямар ч нэр дэвшигч сонгогдохгүй бөгөөд хоёр дахь шатны сонгууль явагдана. Зөвхөн эхний шатны эхэнд эрэмбэлэгдсэн хоёр нэр дэвшигч л хоёр дахь шатанд өрсөлдөнө. **Хоёр дахь шатны сонгууль 2022 оны 9-р сарын 30-ны Баасан гарагт 14:00-22:00 цагийн хооронд, 2022 оны 10-р сарын 1-ний Бямба гарагт 8:00-14:00 цагийн хооронд явагдана.** Хэрэв хоёр дахь шатны сонгууль болохоос өмнө нэр дэвшигч нэрээ татсан, нэр дэвших эрхээ хасуулсан эсвэл нас барсан бол, эхний шатны сонгуульд гуравт орсон нэр дэвшигч хоёр дахь шатны сонгуульд оролцоно. Энэ тохиолдолд, хоёр дахь шатны сонгууль 2022 оны 10-р сарын 7-ны Баасан гарагт 14:00-22:00 цагийн хооронд, 2022 оны 10-р сарын 8-ны Бямба гарагт 08:00-14:00 цагийн хооронд явагдах боломжтой.

Хоёр дахь шатны саналын хуудсыг (саарал өнгөтэй) сонгогчдод урьдчилж өгөхгүй. Харин сонгуулийн өдөр санал авах байр руу шууд хүргэнэ.

Хамар, амны хамгаалалт зүүх шаардлагын тухай сүүлийн үеийн мэдээллийг дагаж мөрдөнө үү. Анхаарал болгоомжтой байж, зөвлөж буй халдварын эсрэг арга хэмжээг дагаж мөрдөнө үү.